

ТАНИЛЦУУЛГА

Хүнсний гол нэрийн барааны үнэ,
2018 оны 6-р сарын 6-ны байдлаар


2018 оны 6-р сарын 6-ны байдлаар гол нэрийн барааны үнийг өмнөх сартай харьцуулахад 1.1 хувь, өмнөх 7 хоногтой харьцуулахад 0.2 хувиар өссөн байна.

Махны дундаж үнэ: 2018 оны 6-р сарын 6-ны байдлаар хонины ястай махны үнэ өмнөх сараас 0.4 хувь, үхрийн ястай махны үнэ 0.4 хувь, үхрийн цул махны үнэ 1.8 хувь, ямааны ястай махны үнэ 0.5 хувиар өссөн байна. Харин адууны ястай махны үнэ өөрчлөлтгүй байна.

Өмнөх 7 хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ өмнөх сараас 0.5 хувь, үхрийн ястай махны үнэ 0.3 хувь, үхрийн цул махны үнэ 2.1 хувиар өссөн бол ямааны ястай мах болон адууны ястай махны үнэ өөрчлөлтгүй байлаа.

2018 оны 6-р сарын 6-ны байдлаар 1 кг хонины /ястай/ мах дунджаар 7520 төгрөг, үхрийн /ястай/ мах 8500 төгрөг, үхрийн цул мах 10375 төгрөг, адууны /ястай/ мах 6075 төгрөг, ямааны /ястай/ мах 5065 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).


Зураг 1. Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ



Гурилын үнэ: 2018 оны 6-р сарын 6-ны гурилын үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногтой харьцуулахад гурилын үнэ өөрчлөлтгүй байна.

Будаа, элсэн чихрийн дундаж үнэ: 2018 оны 6-р сарын 6-ны байдлаар цагаан будааны үнэ, элсэн чихрийн үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад өөрчлөлтгүй байна. (Зураг2).

Зураг 2. Цагаан будаа, элсэн чихэр, төмсний дундаж үнэ



Төмс, хүнсний ногооны дундаж үнэ: 2018 оны 6-р сарын 6-ны байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад төмсний үнэ 15.3 хувь, хүрэн манжингийн үнэ 1.6 хувь, луувангийн үнэ 17.6 хувь, байцааны үнэ 4.2 хувиар өссөн байна. Харин сонгины үнэ өөрчлөлтгүй байна. Өмнөх 7 хоногийнхоос хүнсний ногооны үнэ өөрчлөлтгүй байна.

Сүү, өндөг, ургамлын болон цөцгийн тосны дундаж үнэ: 2018 оны 6-р сарын 6-ны байдлаар сүүний үнийг өмнөх сарынхтай харьцуулахад савласан /1 литрийн/ сүүний үнэ 0.7 хувь, задгай сүүний үнэ 2.0 хувь, “элекстер” /0.5 литрийн/ сүүний үнэ 0.4 хувиар буурсан байлаа. Өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад савласан /1 литрийн/ сүүний үнэ 0.2 хувь, задгай сүүний үнэ 2.0 хувиар буурсан байлаа.

Ургамлын тосны үнэ өмнөх сараас болон өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй байлаа. Цөцгийн тосны үнэ өмнөх сараас 0.1 хувиар өсөж, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байлаа.